ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ
ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД

ИРГЭД ХЭРХЭН ОРОЛЦОХ ВЭ?



ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНЭ ЦЭНИЙГ ХАМГААЛАН, ЗҮЙ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭХ

ШААРДЛАГАГҮЙ ХЭРЭГЛЭЭНЭЭС ТАТГАЛЗАХ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШИГТАЙ ЦАХИЛГААН ХЭРЭГСЛИЙГ АШИГЛАХ

Ж.Самбуугийн гудамж-30, Бага тойруу,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201

976-11-320126
976-11-313203

E-mail: info@erc.mn
www.erc.gov.mn
www.ecc.erc.gov.mn

Эрчим хүчний үнэ цэнэ



ЭРЧИМ ХҮЧ
ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ

ХУУЛЬ

БИДЭНД ХЭРЭГТЭЙ ЮУ?



ЭРЧИМ ХҮЧ


ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ

БИДЭНД ХЭРЭГТЭЙ ЮУ?

Хуулийн гол зорилго нь эрчим хүчний хэрэглээ өндөртэй аж ахуйн нэгж, байгууллагуудыг үүрэг хүлээлгэх замаар эрчим хүчний үр ашгийг нь дээшлүүлж хэмнэлт гаргахад оршино.

Эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, хэрэгжилтийг хангуулахыг Эрчим хүчний зохицуулах хороо хариуцна.

ЭРЧИМ ХҮЧ ХЭРЭГЛЭГЧ



ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН ХЭРЭГЛЭГЧ

Эрчим хүчний жилийн хэрэглээ нь харьцангуй өндөр иргэн, аж ахуйн нэгж, байгууллага буюу Засгийн газраас тогтоосон эрчим хүчний хэрэглээний босго хэмжээг давсан хэрэглээтэй бол Та болон Танай байгууллага хуулийн хүрээнд цахилгаан, дулааны эрчим хүчийг заавал хэмнэж ажиллах ёстой.

Үүрэг хүлээсэн хэрэглэгч Таны эрчим хүчтэй холбоотой бүх төрлийн зардал буурч, технологи, дамжлагын бүтээмж нэмэгдэх, ажиллах нөхцөл сайжрах, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах зэрэг ач холбогдолтой.



БУСАД ИРГЭН, ААНБ

Хуулиар эрчим хүч хэмнэх асуудлыг нээлттэй үлдээж, эрчим хүчний үр ашгийг сайжруулах мэргэжлийн үйлчилгээг ашиглах, зөвлөгөө авч болно.

Орон байраа дулаалахаас эхлэх Таны санаачлага амьдралын тань чанарыг сайжруулах суурь алхам болно.

ТА ЭРЧИМ ХҮЧЭЭ ХЭРХЭН

ЗӨВ, ЗОХИСТОЙ

ХЭРЭГЛЭХ ВЭ?



ЦАХИЛГААНГҮЙ, ДУЛААНГҮЙ хэр удаан амьдарч чадах вэ?

19 дүгээр зуунд бид чадах байсан биз!

Таны төсөөлөл эрчим хүчний үнэ цэнийг бататгана.



ЗУРАГТ ҮЗЭХГҮЙ



ХООЛ ХИЙХГҮЙ, ХӨРГӨГЧ АЖИЛЛАХГҮЙ



ГАР УТАС, ИНТЕРНЕТ БАЙХГҮЙ



БУСАД ТӨСӨӨЛЛИЙГ ТАНД ҮЛДЭЭЕ!

Цахилгаан, дулаан гэдэг Таны хэрэгцээг хангаж, хүссэн үедээ хэрэглэх боломжийг олгодог ОНЦГОЙ бүтээгдэхүүн юм.

Төсөөлөл бүхэн биелэхгүй ч төсөөлшгүй эрсдэл ойрхон байдаг.

Та цахилгаан, дулааны эрчим хүчийг хэмнэх тал дээр анхаарч, гэр бүлдээ, ажлын байрандаа хэвшил болгож чадвал энэхүү хуулийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ байгаль орчноо хайрлаж буй алхам болно.



ШИМЭГЧ-1:

ЗУРАГТЫГ УДИРДЛАГААР УНТРААХ



ШИМЭГЧ-2:

ГАР УТАСНЫ ЦЭНЭГЛЭГЧИЙГ САЛГАХГҮЙ ҮЛДЭЭХ



ШИМЭГЧ-3:

КОМПЬЮТЕР, ПРИНТЕРЭЭ ТЭЖЭЭЛЭЭС САЛГАХГҮЙ ОРХИХ

Эрчим хүчийг хэмнэх асуудал нь өөрийн хэрэглээнээс татгалзах асуудал биш бөгөөд үр ашигтай байдлаар өөрийн хэрэгцээг хангахын зэрэгцээ, амьдралын дадал, хэвшлээ өөрчлөх замаар бий болгох ухамсарт үйлдэл юм.